

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
БАЙГУУЛЛАГУУДЫН 2020 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН
ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН**

Огноо: 2021 оны 4 дүгээр сарын 25

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	САГ-2021/17/СТА-ТЕЗ	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Аудитын хоёрдугаар газар	Аудит хийсэн баг, албан тушаалтан	Ахлах аудитор Р.Цолмон

Хоёр. Байгууллага, нэгжийн тоо болон санал дүгнэлтийн талаарх мэдээлэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр/ангилал	Байгууллага, нэгжийн тоо					Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудит хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	6	7	8	9	10
1	Төсвийн шууд захирагч	94	77	11	6		70	6	1	
2	Төвлөрүүлэн захирагч	3	3				1	2		
3	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1	1				1			
4	Төсвийн ерөнхийлөн захирагч	1	1					1		
ДҮН		99	82	11	6		72	9	1	

Гурав. Аудитын үр дүн

3.1. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөг/

Д/д	Санхүүгийн тайланд нэгтгэсэн байгууллага, нэгжийн нэр	Алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
				Зөвлөмж		Төлбөрийн акт		Албан шаардлага		Албан тушаалтанд хариуцлага тооцуулах	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	2	3	4	5	6	7	8	9	10	11	12

1	Төсвийн шууд захирагч	221	3,412.7	119	2,282.6	28	123.4	74	1,006.7		
2	Төсвийн төвлөрүүлэн захирагч	11	923.6	4	712.7	1	9.6	6	201.3		
3	Төрийн өмчит аж ахуйн нэгж	1	67.0	1	67.0						
4	Төсвийн ерөнхийлөн захирагч	2	0.0	2	0.0						
	Дүн	235	4,403.3	126	3,062.3	29	133.0	80	1,208.0		

3.2 . Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг ач холбогдлоор нь эрэмбэлбэл:

Алдаа, зөрчилтэй асуудал 1

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 91,600.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 87,197.2 сая төгрөгийн алдааг залруулж, 133.0 сая төгрөгийн 29 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,208.0 сая төгрөгийн 80 албан шаардлага, 3,062.3 сая төгрөгийн алдаа, зөрчилд 126 зөвлөмж өглөө.

Шийдвэрлэсэн нь:

Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг барагдуулах, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмж өгсөн.

Алдаа, зөрчилтэй асуудал 2

Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагууд тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 1378 мэдээллээс 254 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 10 мэдээллийг байршуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Харьяа байгууллагуудын шилэн дансанд тавих хяналтыг сайжруулж, Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т заасныг баримтлан ажиллах зөвлөмж өгсөн.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2021.04.26 № 1338

танай _____-ны № _____-т

Аудитын санал дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Монгол Улсын Шадар сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар залруулагдаагүй нийт 4,403.3 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй, "Эрх ба үүрэг", "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.


Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ